



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 30 өдөр Дугаар 30

Хэрлэн сум

ХХХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94,4 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан хурлын шийдвэрүүдийн биелэлтийг танилцуулах:

Аймгийн Онцгой комиссын гишүүд

2.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн тайланг танилцуулах:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

3.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн санд дотоод аудит хийсэн дүгнэлтийг танилцуулах:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат,

4.Газрын тос тээвэрлэлтийн талаар танилцуулах:

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

5.Автотээврийн үзлэг, оношлогооны талаар:

Авто тээврийн төвийн дарга Ц.Мөнхтөр

6.ОХУ-аас хилийн Эрэнцав боомтоор орж ирэх хүсэлт гарсан иргэдийн хүсэлтийг хэлэлцэх:

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

7.Хог цэвэрлэгээний ажлын явцын талаар танилцуулах:

Хэрлэн сумын Засаг даргын орлогч дарга О.Пүрэв-Очир

8.Эрчим хүчний сайд, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-аас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад хариу албан бичиг ирүүлснийг танилцуулах:

*Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ*

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

1.1.Гэрээр тусгаарлалтанд байгаа иргэдийг гар утсаар хянах хяналтыг эрчимжүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

1.2.Аймгийн Прокурорын газар, Шүүхийн Тамгын газарт Улсын Онцгой комиссын 2020 оны 17 дугаар хуралдааны 8.1 дэх заалтын дагуу албан бичгийг хүргүүлж санал авахыг,

Хоёр.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

2.1.Хэрлэн сумын 6 дугаар багийн 24 дүгээр байрны ойр орчны асуудлыг шийдвэрлэх саналыг аймгийн Онцгой комиссын 31 дүгээр хуралд танилцуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой
комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.2.Аймгийн Автотээврийн төвөөс аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу Чойбалсан хотоос сумдад тээвэрлэлт хийдэг жолооч нарт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зориулж гар ариутгагч /жавелион/ 2 хайрцаг худалдан авах зардал 100,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Автотээврийн төвд олгохыг,

2.3.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын бичиг хэргийн зардалд 95,000 төгрөг, холбооны зардалд 60,000 төгрөг, нийт 155,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

3.1.Дэн буудлын үйл ажиллагааг нээхтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Онцгой комиссын 31 дүгээр хуралд танилцуулахыг,

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

3.2.Аймгийн Онцгой комиссоос шийдвэрлэсний хандив тусламжийн санхүүгийн материалд алдаа дутагдал гаргахгүй байхыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од,

Хилийн 0198 дугаар ангийн захирагч Ж.Эрдэнэчулуун,

Халхгол сумын Засаг дарга Т.Хүрэл-Эрдэнэ нарт:

4.1.Хилийн Баянхошуу боомтоор газрын тосны тээвэрлэлт хийхдээ өдөрт 24-өөс дээш автомашин зорчуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

4.2.Аймгийн Онцгой комиссоос Петро чайна дачин тамсаг ХХК-д албан бичгээр хүргүүлсэн 7 төрлийн чиглэлийн дагуу тус компанийн ажилчид ээлж солих үед хяналт тавьж ажиллахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

4.3.Петро чайна дачин тамсаг ХХК-д хилийн Баянхошуу боомтоор газрын тосны тээвэрлэлт хийхдээ өдөрт 24-өөс дээш автомашин боомтоор зорчуулахгүй тухай албан бичиг хүргүүлэхийг,


Тав.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

5.1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоог орон нутгийн хэмжээнд зохион байгуулах талаар чиглэл авах тухай албан бичгийг боловсруулж Монгол Улсын Шадар сайд, Онцгой комиссын дарга, Шуурхай штабын даргад аймгийн Онцгой комиссоос хүргүүлэхийг,

Зургаа.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:


6.1.Иргэдээс аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн ОХУ-аас Монгол Улс руу нэвтрэх хүсэлтийг Улсын Онцгой комисст уламжилж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА



Д.БАТТУЛГА

ТУ32095 0720030013 9029346